



**ХЭНТИЙ АЙМГИЙН
МӨРӨН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 02 сарын 10 өдөр

Дугаар Б/05

Мөрөн сум

**Зөөлөн багийн Засаг даргыг
томилох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 56 дугаар зүйлийн 56.6 дахь хэсэг, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6 дахь хэсэг, Засгийн газрын 2024 оны "Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 238 дугаар тогтоолын 12 дугаар хавсралт, Улсын их хурлын 2007 оны "Улс төрийн албан тушаалын албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдлийг шинэчлэн тогтоох тухай" 73 дугаар тогтоол, Засгийн газрын 2024 оны "Төрийн захиргааны, үйлчилгээний болон улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид орон нутгийн нэмэгдэл олгох тухай" 82 дугаар тогтоол, Зөөлөн багийн иргэдийн Нийтийн хуралдааны 2025 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн 07 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2025 оны 02 дүгээр сарын 10-ны өдрөөс (Сүмбэнбаатарын Сүхчулуун)-ыг Зөөлөн багийн Засаг даргаар томилсугай.

2. Зөөлөн багийн Засаг дарга С.Сүхчулууны үндсэн цалинг 1,458,000 (нэг сая дөрвөн зуун тавин найман мянган) төгрөг, онцгой нөхцөлийн нэмэгдлийн үндсэн цалингийн 30 хувиар, орон нутгийн нэмэгдлийн 40 хувиар тус тус тооцож олгохыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Б.Нандин-Эрдэнэ)-д зөвшөөрсүгэй.

3. Хууль тогтоомжид заасан бүрэн эрхээ хэрэгжүүлж, хүний эрх, эрх чөлөөг дээдлэн, төрийн албаны сахилга хариуцлагыг чанд мөрдөн ажиллахыг Зөөлөн багийн Засаг дарга С.Сүхчулуун-д үүрэг болгосугай..

ДАРГА

Н.ХАТАНБААТАР